

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журмын 11 дүгээр хавсралт

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2018.05.22

Чойр хот

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<p><u>1.Мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар бүрэн цахимд байршуулах</u></p> <p>Байгууллагын цахим хуудсанд 11 үндсэн цэс, 34 дэд цэсэнд 37 мэдээлэл, 70 pdf ,jpeg, 74зурган файл оруулсан ба фейсбүүкээр 87 мэдээлэл,250 зурган файл оруулж статистикийн болон хэлтсийн үйл ажиллагааг нийтэд сурталчилсан байна. Нээлттэй хаалганы өдөрлөгийг Баянтал, Сүмбэр сумдад хийж 120 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлж , “Сонирхолтой статистик” мэдээлэлээр 60 иргэнд үйлчилж, улс, аймгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр нугалбар бэлтгэн тарааж, 30 иргэнд хуулийн зөвлөгөө өгсөн байна.</p> <p><u>2. Байгууллагын мэдээллийн самбарт иргэдэд харагдахуйц газарт байрлуулж, мэдээллийг тогтмол шинэчлэх</u> Хэлтсийн гадна талд 2 мэдээллийн самбарыг байршуулан иргэдэд ил тод , нээлттэй , ойлгомжтой хэлбэрээр цаг үеийн мэдээллийг хүргэж байна. Санхүүгийн болон шаардлагатай мэдээллүүдийг цаг хугацаанд нь тавьдаг.</p>	100%

2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Өргөдөл ,гомдол хүлээн авах албан хаагчийн нэр, харилцах утас зэргийг тодорхой бичин цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. . 2018 онд 1 өргөдөл хүлээн авч бүртгэн ҮСХорооны шийдвэрийн дагуу шийдсэн.	100%
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журмыг хэлтсийн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан сурталчилж байна.Үр дүн нь нийтэд зарлагдсан статистикийн мэдээ, судалгааг иргэдэд цахимаар болон хэвлэмэл байдлаар үнэ төлбөргүй хүргэдэг.	100%
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	govisumber.nso.mn”цахим хуудсандаа нэн шаардлагатай 12 хууль, 16 дүрэм, журмуудыг татаж авах боломжтойгоор байршуулсан. Мэдээллийн самбарт эдгээрээс шинээр гарсан дүрэм журмуудыг байршуулан сурталчилж байна.	100%
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний акт байхгүй байна.	100%-
Хэсгийн дундаж хувь:100%			

Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;

1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	одоогоор сул ажлын байр байхгүй байна.	100%
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<p>ТАХ-ийн ёс зүйн дүрмийг цахим болон мэдээллийн самбарт иргэдэд харагдахуйц ойлгомжтой байдлаар байршуулан сурталчилдаг. Албан хаагчдын ёс зүй болон хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэлтсийн сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Сургалтын мэдээг байгууллагын цахим хуудас, фейсбүүк болон мэдээллийн самбарт байршуулахаас гадна ҮСХороонд тогтмол мэдээлж ажилладаг. Одоогийн байдлаар ёс зүйн сургалтыг 1 удаа, хууль эрх зүйн сургалтыг 3 удаа зохион байгуулаад байна.</p> <p>ҮСХорооны даргын тушаалаар баталсан ёс зүйн хороогоор аливаа ёс зүйн зөрчлийг шийдвэрлүүлдэг бөгөөд одоогийн байдлаар манай хэлтсээс ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна.</p>	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн үзүүлэлт, тайлан мэдээг цахим болон мэдээллийн самбарт байршуулсан ба дүгнэх журмыг татаж авах боломжтойгоор цахим хуудсанд байршуулсан.	100%

4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Байгууллагын бүтэц орон тоо баталсан ҮСХорооны даргын шийдвэрийг цахим болон мэдээллийн самбарт иргэдэд ойлгомжтой байдлаар байршуулан иргэдэд мэдээлэхээс гадна хэлтсийн даргын 2018 оны эхний 5 сард гаргасан тушаалыг цахим хуудсандаа байршуулсан.	100%
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	ҮСХорооны даргын баталсан дотоод журамд урамшууллын заалтууд тусгагдсан байдаг ба системийн хэмжээнд мөрдөж ажилладаг. Албан хаагчдын зэрэг дэв, ажилласан жилийн нэмэгдлийг ҮСХорооноос тогтоосноор олгодог ба ажилласан жил, зэрэг дэвийн нэмэгдлийг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулсан.	100%
Хэсгийн дундаж хувь:100%			
Хэрэгжилтийн дундаж хувь:100%			

ТАЙЛАНГ ГАРГАСАН:

/Д.ОЮУНЦЭЦЭГ/

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

/Л.МӨНГӨНЦЭЦЭГ/

